



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/4321

Булган сум

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Шадар Сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 129 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашиглаж байгаа барилга, байгууламжийн паспортжуулалтын ажлын даалгавар боловсруулах, мэргэжлийн дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, техникийн асуудал хэлэлцэх, шийдвэр гаргах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Аймгийн Ерөнхий архитектор
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч
Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч

Сумдын Засаг дарга нар
Байгууллагын дарга, эрхлэгч нар
Нарийн бичгийн дарга: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулж, шаардлагатай төсөв хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган ажиллаж, хагас бүтэн жилээр тайлагнаж байхыг паспортжуулалтын зөвлөл (Аймгийн Засаг даргын орлогч)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/232 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж

6325010683